



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 599

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 8 нэрийн нийт 7,098,824.48 (долоон сая ерэн найман мянга найман зуун хорин дөрвөн төгрөг дөчин найман мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, харьяа байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны дүгээр сарын ...-ны өдрийн
599 дугаар тогтоолын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1. Онги таац голын сав газрын захиргаа					
1	Мотоцикль	10/28/2014	1	1,698,000.00	1,698,000.00
2	Мотоцикль	6/9/2014	1	1,790,250.00	1,790,250.00
Хэсгийн дүн			2	3,488,250.00	3,488,250.00
2. Тарвагатайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа					
3	Модон хайс /рашаант баг/	12/31/2018	31.2	1,197.14	37,350.77
4	Модон хайс /Цэцүүх баг/	12/31/2018	70.98	1,197.15	84,973.71
Хэсгийн дүн			102	2,394.29	122,324.48
3. Үенч бодонч голын сав газрын захиргаа					
5	Мотоцикль LIPAN	1/1/2014	1	1,698,000.00	1,698,000.00
6	Мотоцикль LIPAN	1/1/2015	1	1,061,250.00	1,061,250.00
Хэсгийн дүн			2	2,759,250.00	2,759,250.00
4. Хар нуур Ховд голын сав газрын захиргаа					
7	Мотоцикль Li Fan	10/23/2016	1	1,698,000.00	1,698,000.00
Хэсгийн дүн			1	1,698,000.00	1,698,000.00
5. Сэлэнгэ голын сав газрын захиргаа					
8	Хятад мотоцикл	6/9/2014	1.00	1,790,250.00	1,790,250.00
Хэсгийн дүн			1	1,790,250.00	1,790,250.00
					7,098,824.48
НИЙТ ДҮН				(долоон сая ерэн найман мянга найман зуун хорин дөрвөн төгрөг дөчин найман мөнгө)	